



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 207

Мандалговь

**Хөрөнгө бүртгэлд авах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.2, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 “б”, “г” дэхь заалтуудыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн 3'402'894'117 /гурван тэрбум дөрвөн зуун хоёр сая найман зуун ерэн дөрвөн мянга нэг зуун арван долоо/ төгрөгийн өртөгтэй 4 нэр төрлийн эд хөрөнгийг хавсралтын дагуу Дундговь–Ус ОНӨҮГазрын үндсэн хөрөнгөд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгүүдийг байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэж авахыг Дундговь–Ус ОНӨҮГ-ын захирал /Р.Энхмаа/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С БУДЖАВ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2013 оны...11...сарын...20...ний өдрийн  
...207...-р тогтоолын хавсралт



**Үндсэн хөрөнгөний бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд дүн
1	12-р сангийн шугам	м	750	26608.498	19956.366
2	9-р сангийн барилга	ш	1	4,036,207.80	4036.207
3	Олгойн говийн цэвэр усны шугам	м	30056	110423.001	3318901.543
4	ДТХ-07 халуун усны тогоо	ком	2	30000.0	60000.0
	Дүн		<b>30809</b>		<b>3402894.117</b>

Өмчийн алба